



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК

Танилцуулга
2019 оны 4 дүгээр сар


Улаанбаатар
2019



1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ


Мөнгөний нийлүүлэлт буюу M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 22.6 хувиар өсч 19.9 их наяд төгрөгт хүрлээ. M2 мөнгөний жилийн өсөлтийн 12.5 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 5 нэгж хувийг төгрөгийн харилцах, 2.8 нэгж хувийг гадаад валютын харилцах, 2.4 нэгж хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлсэн байна.

M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 22.6%-иар нэмэгдсэн байна.




Нийт хадгаламжийн хэмжээ 13.8 их наяд төгрөгт хүрснээс 80.4 хувь буюу 11.1 их наяд төгрөг нь иргэдийн, 19.6 хувь буюу 2.7 их наяд төгрөг нь байгууллагын хадгаламж байна. Нийт хадгаламжийн 20.7 хувь нь гадаад валютын хадгаламж байна. Харин иргэдийн хадгаламжийн 19.4 хувийг, байгууллагын хадгаламжийн 25.9 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.

Нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 21.1%-иар өсч 13.8 их наяд ₮-т хүрчээ.




Өмнөх сартай харьцуулахад мөнгөний нийлүүлэлт 209.9 тэрбум төгрөгөөр өсчээ. Энэ өсөлтөд улсын байгууллагын гадаад валют болон төгрөгийн харилцах нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Харин хувийн байгууллагын төгрөгийн харилцах, иргэд болон санхүүгийн байгууллагын төгрөгийн хадгаламж буурчээ.

M2 өмнөх сараас 209.9 тэрбум ₮-өөр нэмэгдсэн байна.



M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 18.5 их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн 1.4 их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал M2 мөнгөний өсөлтийн 17.3 нэгж хувийг ГЦА-ын өсөлт, үлдсэн 5.3 нэгж хувийг ДЦА-ын өсөлт бүрдүүлжээ. ГЦА-ын өсөлт Төв Банкны гадаад цэвэр активын, харин ДЦА-ын өсөлт хадгаламжийн байгууллагын олгосон зээлийн өсөлтөөр тайлбарлагдаж байна.

M2 мөнгөний жилийн өсөлтийн дийлэнх хэсгийг ГЦА-ын өсөлт бүрдүүлж байна.



2. БАНКУУДЫН ЗЭЭЛ

Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 22.0 хувиар, үүнээс иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 27.9 хувиар өсч 9.1 их наяд төгрөгт, хувийн байгууллагынх 15.2 хувиар өсч 8.2 их наяд төгрөгт тус тус хүрчээ.


Нийт зээлийн үлдэгдэл 17.5 их наяд ₮-т хүрч, жилийн 22.0%-иар өсөв.



Нийт зээлийн үлдэгдлийн 14.9 хувь буюу 2.6 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний валютын зээл байна. Тодруулбал иргэдийн зээлийн 1.6 хувь, хувийн байгууллагын зээлийн 29.3 хувь нь гадаад валютаар олгогдсон байна.

Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 244.4 тэрбум төгрөгөөр, эргэн төлөгдсөн зээл 263.1 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ. Шинээр олгосон зээлийн 12.6 хувь буюу 241.1 тэрбум төгрөгийг гадаад валютаар олгожээ.

Тайлант сард 1,918.8 тэрбум ₮-ийн зээл олгогдож, 1,727.4 тэрбум ₮ эргэн төлөгдлөө



Өмнөх сартай харьцуулахад нийт зээлд эзлэх чанаргүй зээл болон хугацаа хэтэрсэн зээл тус бүр 0.4 нэгж хувиар өссөн байна. Чанаргүй зээлийн 84.9 хувийг, хугацаа хэтэрсэн зээлийн 79.3 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.


Чанаргүй зээл нь нийт зээлийн 11.1%, хугацаа хэтэрсэн зээл 5.6% байна



Чанаргүй зээлийн үлдэгдэл 1,943.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх сартай харьцуулахад 73.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээлийн 19.7 хувь нь гадаад валютаар олгогджээ.


Чанаргүй зээлийн 22.4 хувийг уул уурхай, 21.8 хувийг боловсруулах, 15.2 хувийг барилга, 8.3 хувийг үл хөдлөх хөрөнгийн салбарын зээл эзэлж байна.

Чанаргүй зээл, салбараар. Чанаргүй зээлийн 84.9 хувь нь хувийн байгууллагын, 14.6 хувь нь иргэдийн зээл байна



Тайлант сард хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл өмнөх сараас 140.5 тэрбум төгрөгөөр өсчээ. Үүнд, уул уурхайн салбарын зээл 67.8 тэрбум, худалдааны салбарын зээл 66.0 тэрбум, барилгын салбарын зээл 43.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн дийлэнх хувийг худалдаа, барилга, боловсруулах, уул уурхайн салбарын зээл бүрдүүлэв



Тайлант сард хувийн байгууллагад 942.2 тэрбум төгрөгийн зээл олгогдсоны 21.4 хувь буюу 201.1 тэрбум төгрөгийн зээл гадаад валютаар олгогджээ. Худалдаа, уул уурхай, боловсруулах, барилгын салбарт дийлэнх зээл олгогдсон байна.

Хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн бүтэц



Иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 44.5 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнээс ипотекийн зээл 46.8 тэрбум, худалдааны зээл 46.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн. Харин цалин, тэтгэврийн зээл 42.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Иргэдийн зээлийн 37%-ийг орон сууцны зээл (МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар), 36%-ийг цалин, тэтгэврийн зээл бүрдүүлэв




Тайлант сард иргэдэд 933.1 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 4.1 хувь буюу 38.4 тэрбум төгрөгийн зээл гадаад валютаар олгогджээ. Иргэдэд шинээр олгосон зээлийн дийлэнх буюу 22.6 хувийг хадгаламж барьцаалсан, 14.9 хувийг цалин, тэтгэврийн, 13.2 хувийг картын зээл тус тус бүрдүүлсэн байна.

Иргэдэд шинээр олгосон зээлийн бүтэц



ЖДҮ-ийн зээлийн дийлэнх хувийг худалдаа, боловсруулах, барилгын салбарын зээл эзэлж байна



ЖДҮ эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд олгосон нийт зээлийн үлдэгдэл 3,681.2 тэрбум төгрөгт хүрснээс 32.7 хувийг худалдааны салбарт, 15.6 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 11.7 хувийг барилгын салбарт, 7.8 хувийг үйлчилгээний салбарт тус тус олгосон байна. ЖДҮ-ийн зориулалтаар олгосон нийт зээлийн үлдэгдлийн 3.5 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 15.1 хувь нь чанаргүй зээлд ангилагдсан байна.

3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ


2019 оны 4 дүгээр сарын байдлаар 94,146 зээлдэгч нийт 4.44 их наяд төгрөгийн ипотекийн зээлтэй байна. Үүнээс хөтөлбөрийн эх үүсвэрээр 69,495 зээлдэгч 3.3 их наяд төгрөгийн зээл авчээ.

Ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт: 4.1%



Ипотекийн зээлийн үлдэгдлийн 74.3 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 23.6 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 2.1 хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл байна.

Ипотекийн зээлийн 74.3 хувийг хөтөлбөрийн зээл эзэлж байна.



Орон нутгийн ипотекийн зээл¹-ийн 77.94 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 21.24 хувь нь банкны өөрийн эх үүсвэрээр, 0.82 хувь нь бусад эх үүсвэрээр олгогдсон ба нийт 24625 ипотекийн зээлдэгч байна.


Нийт ипотекийн зээлийн 933.8 тэрбум төгрөг буюу 21.0 хувь нь орон нутаг дахь банкны салбараас олгосон зээл байгаа бол худалдан авсан орон сууцны байршлаар нь авч үзвэл нийт зээлийн 17.1 хувь болох 759.5 тэрбум төгрөг орон нутагт ногдож байна.

¹ Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршлаар тооцсон.

Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 17.1 хувийг орон нутагт байршилтай орон сууцанд олгожээ.



Ипотекийн зээлийн 82.9 хувь нь Улаанбаатар хотод байршилтай орон сууц худалдан авахад зарцуулагджээ.



Тайлант сард 66.5 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноос 45.2 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 54.8 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.

Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 95.4 хувь нь хэвийн, 2.6 хувь нь хугацаа хэтэрсэн, 2.0 хувь нь чанаргүй зээл байна. Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн 56.9 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 41.6 хувийг хөтөлбөрийн зээл, 1.5 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна.


Өмнөх сараас хугацаа хэтэрсэн зээл 4.4 тэрбум төгрөгөөр буурсан бол, чанаргүй зээл 3.0 тэрбум төгрөгөөр өсөв.



Тайлант сард шинээр 923 зээлдэгчидэд ипотекийн зээл шинээр олгожээ.



Шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх сараас 1.7 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар тус тус буурчээ.




4. ТӨГРӨГИЙН ГАДААД ВАЛЮТТАЙ ХАРЬЦАХ ХАНШ

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сарын эцсийн байдлаар 2642.78 төгрөгт хүрсэн нь өмнөх сарын эцсээс 0.4 хувиар чангарсан үзүүлэлт байна. Тайлант сарын дундаж ханш нь 2634.93 төгрөг байв.

Төгрөгийн юаньтай харьцах сарын эцсийн ханш өмнөх сараас 0.1 хувиар суларч 392.05 төгрөг байв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 391.58 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 393.84 төгрөг байлаа.

Төгрөгийн ханш ам.долларын эсрэг сулрав.

Төгрөгийн ханш юаны эсрэг сулрав.




5. ХҮҮ

2019 оны 4 дүгээр сард нийт шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 11.1 хувь буюу өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар буурсан байна. Гадаад валютын хадгаламжийн хүү өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар өсч 4.4 хувьд хүрсэн байна. Иргэдээс татсан төгрөгийн хадгаламж 11.5 хувь, хувийн байгууллагаас татсан хадгаламж 10.3 хувийн хүүтэй байна.

Тайлант сард нийт шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 17.5¹ хувьтай бөгөөд өмнөх оны мөн үеэс 1.8 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна. Нийт гадаад валютаар олгосон зээлийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар буурч 9.5 хувьд хүрчээ. Иргэдэд шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү 17.9 хувь, гадаад валютын зээлийн хүү 7.5 хувьтай байна. Харин хувийн байгууллагад олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 17.1 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 9.8 хувьтай байна.


Шинээр татсан нийт хадгаламж, хүү

Шинээр олгосон нийт зээл, хүү



¹ Хөтөлбөрийн зээл, Хөгжлийн банкны санхүүжилтийн зээлийн дүнгүүдийг оруулаагүй болно.

Шинээр татсан нийт хадгаламжийн хүүний тархалт




2019 оны 4 дүгээр сард нийт төгрөгийн хадгаламжийн үлдэгдлээрх ЖДХ 11.8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар буурчээ. Харин нийт гадаад валютын хадгаламжийн ЖДХ 4.9 хувьтай байна. Хадгаламжийн үлдэгдэлд ЖДХ иргэдийн төгрөгийн хадгаламжийн хувьд 11.7 хувь, гадаад валютын хадгаламжийн хувьд 4.8 хувьтай байгаа бол хувийн байгууллагын төгрөгийн хадгаламжийн хувьд 11.1 хувь, гадаад валютын хадгаламжийн 5.3 хувьтай байна.

Нийт хадгаламжийн үлдэгдэл, хүү




Шинээр олгосон нийт зээлийн хүүний тархалт




Мөн тайлант сард нийт төгрөгийн зээлийн үлдэгдлээрх ЖДХ 17.1 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 10.6 хувьтай байна. Үүнээс иргэдийн төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 18.0 хувьтай, гадаад валютын зээлийн ЖДХ 12.5 хувьтай байна. Хувийн байгууллагын зээлийн ЖДХ 15.8 хувьтай, гадаад валютын зээлийн хүү 10.5 хувьтай байна. Нийт төгрөгийн зээлийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар, гадаад валютын зээлийн ЖДХ 0.3 нэгж хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.


Нийт зээлийн үлдэгдэл, хүү



Нийт хадгаламжийн үлдэгдлийн хүүний тархалт



Нийт зээлийн үлдэгдлийн хүүний тархалт



Зээлийн хүү болон хадгаламжийн хүүний зөрүү нь банкуудын активын хөрвөх чадварыг илэрхийлэх үзүүлэлтүүдийн нэг юм. 2019 оны 4 дүгээр сарын байдлаар хүүний зөрүү 6.4 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.4 нэгж хувиар буурсан байна.

Төгрөгийн зээл, хадгаламжийн хүүний харьцаа



Гадаад валютын зээл, хадгаламжийн хүүний харьцаа



6. ИНФЛЯЦИ

Тайлант сард Улаанбаатар хотын жилийн инфляци 7.8 хувьд хүрч өмнөх сараас өссөн байна. Үүнээс 5.9 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 1.9 нэгж хувийг хүнсний барааны үнийн өсөлт бүрдүүлж байна. Хүнснээс бусад барааны үнэд хатуу түлш, автобензин, хувцасны үнийн өсөлт, хүнсний барааны бүлгийн үнэд мах үнийн өсөлт голлон нөлөөлжээ.

УБ хотын хэмжээнд сарын инфляци 0.9 хувьд хүрсэн байна. Өмнөх сараас үнийн түвшин нэмэгдэхэд хүнсний бараа 0.7 нэгж хувийг, хүнснээс бусад бараа 0.2 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Хүнсний барааны үнэ өсөхөд голлон махны үнийн өсөлт нөлөөлжээ.

УБ хотын жилийн инфляци 7.8 хувь




УБ хотын сарын инфляци 0.9 хувь




ХАВСРАЛТ

1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Зураг 1.1. M2 Мөнгөний сарын өсөлтийн бүтэц




Зураг 1.2. Нөөц мөнгөний бүтэц




2. ЗЭЭЛ


Зураг 2.1. Зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт



Зураг 2.2. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа /гол салбараар/



Зураг 2.3. Тайланд сард шинээр олгосон болон төлөгдсөн зээл



Зураг 2.4. Тайлант сард шинээр олгосон зээл (салбараар)




Зураг 2.5. Чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл




Зураг 2.6. Чанаргүй зээлийн дүн



Зураг 2.7. ЖДҮ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдэл




Зураг 2.8. ЖДҮ-ийн зээл дэх чанаргүй зээлийн хувь, салбараар



Зураг 2.9 Хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн бүтэц



Зураг 2.10. Орон нутагт шинээр олгосон, төлөгдсөн зээл



Зураг 2.11. Орон нутгийн зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөг/



Зураг 2.11. Орон нутгийн чанаргүй зээлийн эзлэх хувь



3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ


Зураг 3.1. Ипотекийн зээлийн үлдэгдэл санхүүжилтийн эх үүсвэрээр



Зураг 3.2. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, аймгуудаар




Зураг 3.3. Улаанбаатар хотын ипотекийн зээлийн үлдэгдэл, худалдан авсан орон сууцны байршлаар




Зураг 3.4. Орон нутгийн ипотекийн зээлийн үлдэгдэл




Зураг 3.5. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн ашиглалтанд орсон он



Зураг 3.6. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн талбайн хэмжээ



Зураг 3.7. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн орлогын тархалт



Зураг 3.8. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн насны ангиллаарх зээлийн үлдэгдэл

